

## **ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ**

### **ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААН:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ээлжит тавдугаар хуралдаан 2021 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр хуралдав.

#### **Хуралдаанаар:**

- Зарим хүмүүсийг төрийн дээд одон, медалиар шагнуулах тухай
- “Алдарт эх” нэг, хоёрдугаар зэргийн одонгоор зарим эхчүүдийн шагнуулах тухай.
- Аймгийн ИТХ-ын дэргэдэх “Иргэний зөвлөл”-ийн гишүүнийг нөхөн томилох тухай.
- “Ялгуулсан хутагтын Гандан Рэгдоллин” хийдэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл сунгах тухай асуудлыг хэлэлцэн батлав.

### **АЙМГИЙН ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧИД, ОНЦГОЙ КОМИССТ ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЛЭЭ**

Коронавирус /Covid-19/ -ийн халдвартай тэмцэж буй энэ үед нийгмийн эрүүл мэндийн төлөө ажиллаж байгаа алба хаагч нарт байгууллага, хамт олон, иргэд аймгийн Онцгой комисст Дорнод аймгийн ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчид уриалга гарган аймгийн Онцгой комисст хүмүүнлэгийн тусламж, дэмжлэг үзүүлэх ажлыг эхлүүлжээ.

Тус уриалгад аймгийн ИТХ-ын нийт 37 төлөөлөгчөөс 28 төлөөлөгч дэмжлэг үзүүлэн оролцож, нийт 8 сая 900 мянган төгрөгийн хүмүүнлэгийн тусламжийг өнөөдөр /2021.04.30/-ны аймгийн ИТХ-ын дарга М.Энхтөр, аймгийн ИТХ-ын төлөөлөгч Д.Урансүвд, Т.Лхамдулам, У.Энхчимэг нар гардуулан өглөө.

#### **Хоёр. ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:**

1.Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7 дугаар хавсралтын дагуу Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн үйл ажиллагааны тайлан 92.9 хувьтай дүгнэгдэж, 2021 оны 1/627 албан тоотоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

2.Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2021 оны А/26 дугаар “Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, алба, сумдаас авах мэдээ, тайлангийн хуваарь батлах” тухай захирамжийг тус тус үндэслэн Монгол Улсын Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2021 оны 1 дүгээр улирлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

2021 оны 1 дүгээр улирлын байдлаар 60.7 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн бөгөөд 2021 оны 2/138 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын цахим сан [www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn) сайтад хугацаанд нь байршуулсан болно.

## ГУРАВ. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТАЛААР

### ТӨСВИЙН ОРЛОГЫН ТАЛААР:

Орон нутгийн нийт орлого 29547,7 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 28429,5 сая төгрөг, үүнээс татварын орлого 7823,1 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 7748,1 сая төгрөгт хүрч 75,0 сая төгрөгөөр тасарч, татварын бус 21724,5 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 20681,3 сая төгрөгт хүрч 1043,1 сая төгрөгөөр тасарлаа.

### Орон нутгийн төсвийн нийт орлого

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөндүнгээр/	Өөрчлөлт	
			Тоо	Хувь
002 ОРОН НУТГИЙН ОРЛОГО	29,547,677,300.00	28,429,482,056.99	(1,118,195,243.01)	96.22
003 ТАТВАРЫН ОРЛОГО	7,823,147,400.00	7,748,148,033.82	(74,999,366.18)	99.04
004 Орлогын албан татвар	4,951,091,300.00	4,703,890,534.16	(247,200,765.84)	95.01
016 Хөрөнгийн албан татвар	366,425,300.00	509,677,438.50	143,252,138.50	139.09
021 Бусад татвар, төлбөр, хураамж	2,519,320,900.00	2,611,115,776.28	91,794,876.28	103.64
90041 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,724,529,900.00	20,681,334,023.17	(1,043,195,876.83)	95.20
042 Нийтлэг татварын бус орлого	1,727,929,500.00	1,586,734,195.17	(141,195,304.83)	91.83
049 Хөрөнгийн орлого	9,534,800.00	18,355,000.00	8,820,200.00	192.51
056 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	16,537,240,200.00	16,145,365,800.00	(391,874,400.00)	97.6
058 Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	14,726,831,600.00	15,295,545,300.00	568,713,700.00	103.9
059 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	1,810,408,600.00	849,820,500.00	(960,588,100.00)	46.9

## ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТАЛААР:

Аймгийн төсвийн нийт зарлага 32602,3 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 22734,6 сая төгрөгийн гарсан гүйцэтгэлийг бүрэн санхүүжүүлсэн.

Нийт төсвийн зарлагын

- ✓ Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамжинд 58,5%
- ✓ Тогтмол зардалд 18,3%
- ✓ Бараа үйлчилгээний бусад зардалд 9,8%
- ✓ Хөрөнгийн зардалд 13,4% байна.

Аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 2404,9 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 15295,5 сая төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүллээ.

### Орон нутгийн төсвийн нийт зарлага

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,602,384,900.00	22,734,590,216.01	(9,867,794,683.99)	69.7
Цалинхөлсболоннэмэгдэлурамшил	14,553,547,200.00	12,809,166,579.35	(1,744,380,620.65)	88.0
Ажиллогччооснийгмийндаатгалдтө лөхшимтгэл	1,958,837,500.00	1,722,108,685.04	(236,728,814.96)	87.9
Бараа үйлчилгээний бусад зардал	2,512,637,400.00	1,604,431,779.00	(908,205,621.00)	63.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,402,697,800.00	951,118,745.99	(451,579,054.01)	67.8
Б. ХӨРСНГИЙН ЗАРДАЛ	4,801,485,200.00	1,022,914,700.00	(3,778,570,500.00)	21.3

ЖИЧ: Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн дэлгэрэнгүй мэдээлэлийг Аймгийн ЗДТГ-ын № 15 тоот өрөө, [www.dornod.gov.mn](http://www.dornod.gov.mn) вэб сайт, [70583034](tel:70583034), [70582372](tel:70582372) дугаарын утсаар авч болно

## **Дөрөв. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс аймгийн Засаг даргын захирамжийн биелэлтэд тогтмол хяналт тавьж ажилласан.

Иргэн Б.Батчимэгийн нэхэмжлэлтэй, аймгийн Засаг Дарга хариуцагчтай захиргааны хэргийн шүүх хуралд оролцож, шүүхийн шийдвэрт нь Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан.

Иргэн Н.Ганзоригийн нэхэмжлэлтэй, аймгийн Засаг Дарга хариуцагчтай захиргааны хэргийн шүүх хуралд оролцсон.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2021 оны 1 дүгээр улирлын мэдээг сум, агентлаг байгууллагуудаас авч нэгтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

“Капитал банк” ХХК дахь банкны эрх хүлээн авагчийн нэхэмжлэлтэй аймгийн Засаг даргад холбогдох захиргааны хэрэгт оролцсон.

“Нэг цонхны үйлчилгээний цэг”-т ажиллаж байгаа ажилтан нарт 3 сарын хугацаанд хэрэглэгдэх маск, санитол, нүүрний хаалтыг аймгийн Онцгой комисст хүсэлт гаргаж, шийдвэрлэж өгсөн.

Жаст ойл ХХК-ийн нэхэмжлэлтэй аймгийн Засаг даргад холбогдох захиргааны хэрэгт Давж заалдах шатны шүүх хуралд оролцсон.

Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын нарийн бичгийн үүргийг 7 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэн, Аймгийн онцгой комиссоос гарч буй аливаа шийдвэрийг албажуулж ажилласан.

Дорнод аймгийн Засаг даргын нэхэмжлэлтэй, Монгол Улсын Сангийн сайд хариуцагчтай захиргааны хэрэгт оролцсон.

Монгол Улсын Засгийн газраас бүх нийтийн хөл хорионы дэглэм зарласантай холбогдуулан аймагт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай аймгийн Онцгой комиссын тогтоолыг төслийг боловсруулж, батлуулсан.

“Үүрэг гүйцэтгэгч иргэний автомашиныг албаны хэрэгцээнд ашиглах тухай гэрээ”-ний төсөл боловсруулж аймгийн Онцгой комиссын даргаар батлуулсан.

“Капитал банк” ХХК дахь банкны эрх хүлээн авагчийн нэхэмжлэлтэй, аймгийн Засаг дарга хариуцагчтай захиргааны хэрэгт Давж заалдах шатны шүүхэд гомдлын хариу тайлбарын төсөл бичиж, хүргүүлсэн.

Дорнод аймгийн Хэрлэн сумын 1 дүгээр багийн ахмад настан Санжаа овогтой Даваажавас аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст хандаж “..., Шинэ бүтээл бий болгож патент авч байсан” гэх утга бүхий өргөдөл ирүүлснийг

Оюуны өмчийн газар болон Шинжлэх ухаан технологийн газарт хандаж холбогдох хариуг авсан.

Аймгийн Архивын тасаг нь Монгол улсын Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх” үндэсний хөтөлбөрийн дөрөвдүгээр үе шат, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021 оны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

### **1. Албан хэрэг хөтлөлт, хууль тогтоомж, шийдвэрийн талаар:**

Архивын тасагт 2021 оны 4 дүгээр сарын 30-ний байдлаар ирсэн 6 албан бичгийг хүлээн авч бүртгэн, гадагш 1 тодорхойлолт, 4 албан бичиг боловсруулж явуулав.

Үндэсний төв архивын газраас ирүүлсэн “Салбар архивын үйл ажтллагаагны нийтлэг журам” ын төсөлд саналаа хүргүүлэн ажиллав.

Цуглуулга хөмрөгийн бүртгэлд 1913 1961 дугаар бүхий 48 ХН дугаар өгч бүртгэн нүүр бичилт хийн хадгаламжийн санд байрлуулав.

Мөн Архивын тасгийн үйл ажиллагааны 2019, 2020 оны 34 хадгаламжийн нэгжийг ач холбогдол, он цагийн дараалалаар эмхлэн цэгцэлж үдэж хавтаслан нүүр бичлэг хийв.

Аймгийн 90 жилийн ой болохтой холбогдуулан архивын сан хөмрөгт хадгалагдаж буй хосгүй үнэт болон үнэт, аймгийн яам болон аймгийн АДХГЗ, аймгийн ЗДТГазар, мэдээллийн сангаас болон түүхэн баримтаас аймгийн анхдагч түүхэн үйл явдлыг түүвэрлэн судалгааны ажлыг хийв.

### **2. Баримт ашиглалтын талаар:**

4 дүгээр сард 39 иргэнээс лавлагаа мэдээллийн захиалга хүлээн авч 121 хуулбар, 5 иргэнд 18 оны захиалга хүлээн авч А дансны лавлагаа олгож, 8 тодорхойлолт гаргаж нийт 355 700 төгрөгийн орлого оруулав. Хадгаламжийн сангаас 27 хөмрөгийн 63 хадгаламжийн нэгжийг гаргаж ашиглан бүртгэж буцаан байрлуулав.

2021 оны 4 дүгээр сарын 1-ны өдрөөс 30-ний өдрийг хүртэлх хүртэлх хугацаанд нийт давхардсан тоогоор 34 байгууллагын 15 төрлийн 8820 ширхэг хэвлэмэл хуудасны захиалга авч стандартын дагуу хэвлэж, дугаарлан бүртгэл хөтлөн холбогдох байгууллагуудад нь олгоод байна.

Нийт давхардсан тоогоор 34 байгууллагын 909 700 төгрөгийн төлбөр орох ёстойгоос 20 байгууллагын 542 000 төгрөгийн орлого орсон байна.

Шинээр 2 байгууллагын материалыг хүлээн авч эх хувийг бэлтгэн стандартын дагуу хэвлэж өгөв.

Уншлагын танхимаар 1 иргэнд 1983,1984 онуудын “Дөл” сонины эмхэтгэлийг олгож ашиглуулав.

### **3. Нөхөн бүрдүүлэлт**

Цагаан Овоо сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Степ гоулд” ХХК ны Нуруулдан уусгах талбайн 3,4,5 дугаар хэсгийн байгууламжид холбогдох 13 хадгаламжийн нэгжийн 1700 хуудас зураг төслийн баримтаар сан хөмрөгөө нөхөн бүрдүүлээ.

#### **4.Цахим хэлбэрт оруулсан баримтын талаар:**

2021 онд цахимжуулах төлөвлөгөөг боловсруулж, сар, улирал, өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөн ажиллаж байна.

2021 оны 4 дүгээр сарын 30-ний байдлаар Дорнод аймгийн Төрийн архивын 2 хөмрөгийн 2 дансны 46 хадгаламжийн нэгжийн 5108 хуудас баримтыг шивж байршуулав.

- Цахим холболт- 46 хадгаламжийн нэгжийн 5108 хуудас баримт
- Хүний нэр-15 887
- Байгууллагын нэр-101
- Газар зүйн нэр-750
- Заалт 3604

Хөмрөг 92 буюу Нэгдсэн эмнэлэгийн 1975,1976 оны 6 хадгаламжийн нэгжийн 798 хуудасыг Төрийн архивын программд шивж орууллаа.

#### **5.Бусад:**

Хадгаламжийн сангийн цэвэрлэгээ үйлчилгээг 4 дүгээр сарын 1,29-ны өдрүүдэд, чийг дулааны хэмжилтийн бүртгэлийг 4 дүгээр сарын 2,9,16-ны өдрүүдэд хөтөлж ажиллав.

Архивын тасгийн 2021 оны цахимжуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

Аймгийн Архивын тасаг нь Монгол улсын Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх” үндэсний хөтөлбөрийн дөрөвдүгээр үе шат, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021 оны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

#### **1.Албан хэрэг хөтлөлт, хууль тогтоомж, шийдвэрийн талаар:**

Архивын тасагт 2021 оны 2 дугаар сарын 28-ний байдлаар ирсэн 7 албан бичгийг хүлээн авч бүртгэн, гадагш 2 тодорхойлолт, 2 албан бичиг боловсруулж явуулав.

Төрийн архивын тоо бүртгэлийн тайланг зааврын дагуу гаргаж, Архивын баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалтын мэдээг аймгийн 94 байгууллагаас авч нэгтгэн Архивын Ерөнхий газар хүргүүлэн ажиллав.

## **2.Баримт ашиглалтын талаар:**

2 дугаар сард 52 иргэнээс лавлагаа мэдээллийн захиалга хүлээн авч 136 хуулбар, 11 иргэнд 56 оны захиалга хүлээн авч А дансны лавлагаа олгож, 3 тодорхойлолт гаргаж нийт 514 000 төгрөгийн орлого оруулав. Хадгаламжийн сангаас 24 хөмрөгийн 93 хадгаламжийн нэгжийг гаргаж ашиглан бүртгэж буцаан байрлуулав.

2021 оны 2 дугаар сарын 1-ны өдрөөс 28-ний өдрийг хүртэлх хүртэлх хугацаанд нийт давхардсан тоогоор 41 байгууллагын 15 төрлийн 22 490 ширхэг хэвлэмэл хуудасны захиалга авч стандартын дагуу хэвлэж, дугаарлан бүртгэл хөтлөн холбогдох байгууллагуудад нь олгоод байна.

Нийт давхардсан тоогоор 40 байгууллагын 2 004 500 төгрөгийн төлбөр орох ёстойгоос 46 байгууллагын 2 574 400 төгрөгийн орлого орсон байна.

Шинээр 1 байгууллагын материалыг хүлээн авч эх хувийг бэлтгэн стандартын дагуу хэвлэж өгөв.

Уншлагын танхимаар 2 байгууллагад 5 ХН, 1 иргэнд 1981,1982 онуудын “Дөл” сонины эмхэтгэлийг олгож ашиглуулав.

Мөн Дашбалбар сумын ЗДТГазар, аймгийн ЗДТГазар, Төрийн албаны зөвлөлийн хүсэлтээр газар өмчлүүлсэн тухай, аймгийн анхны даргаар ажиллаж байсан нэр бүхий иргэдийн тухай, төрийн албаны нөөцөд бүртгэлтэй эсэх тухай лавлагааг өгч ажиллав.

## **3.Нөхөн бүрдүүлэлт**

Улаанбаатар хотын “Ди Би Ти Би” ХХК хийж гүйцэтгэсэн Баяндун сумын 100 хүүхдийн дотуур байрны ажилд холбогдох 27 ХН, Улаанбаатар хотын “Бүрэнсүх” ХХК хийж гүйцэтгэсэн Хэрлэн сумын 4 багт баригдсан “Элит таун” хотхоны 135 айлын орон сууцны 1 ээлжийн барилгад холбогдох баримт 19 ХН, Улаанбаатар хотын “Ус орчин” ХХК хийж гүйцэтгэсэн Прокурорын газрын барилгын ажилд холбогдох 21 ХН буюу 3 байгууллагын 64 ХН ийн 3112 хуудас баримтаар сан хөмрөгөө нөхөн бүрдүүллээ.

## **4.Цахим хэлбэрт оруулсан баримтын талаар:**

2021 онд цахимжуулах төлөвлөгөөг боловсруулж, сар, улирал, өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөн ажиллаж байна.

2021 оны 2 дугаар сарын 28-ний байдлаар Дорнод аймгийн Төрийн архивын 4 хөмрөгийн 4 дансны 109 хадгаламжийн нэгжийн 11 750 хуудас баримтыг шивж байршуулав.

- Цахим холболт- 109 хадгаламжийн нэгжийн 11 750 хуудас баримт
- Хүний нэр-75 117
- Байгууллагын нэр-
- Газар зүйн нэр-495
- Заалт 9454

Хөмрөг 92 буюу Нэгдсэн эмнэлэгийн 1979 оны 2 хадгаламжийн нэгжийн 406 хуудасыг Төрийн архивын программд шивж орууллаа.

### **5.Бусад:**

Хадгаламжийн сангийн цэвэрлэгээ үйлчилгээг 2 дугаар сарын 4,18-ны өдрүүдэд, чийг дулааны хэмжилтийн бүртгэлийг 2 дугаар сарын 5,12,19,26-ны өдрүүдэд хөтөлж ажиллав.

Архивын тасгийн 2021 оны цахимжуулах ажлын төлөвлөгөөг боловсруулж батлав.

Төрийн архивын нөхөн бүрдүүлэх үндсэн болон боломжит эх үүсвэрийн жагсаалтыг боловсуулах ажлыг хийж байна.

### **Тав. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

***Нэг. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
Биеийн тамир, спортын газар***

#### **Зохион байгуулалтын арга хэмжээ:**

Улс орон даяар гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд бүх төрлийн спортын бэлтгэл, сургуулилтыг түр зогсоогоод байна.

Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабт нэмэлтээр хуваарийн дагуу 2 удаа, урьдчилсан сэргийлэх шинжилгээ, оношилгооны ажилд 1 жолооч тус тус ажилласан.

#### **Сургалт, семинар:**

Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулсан 3 удаагийн цахим сургалтад нийт 5 албан хаагч хамрагдсан.

***Хоёр. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
Боловсрол, соёл, урлагийн газар***

#### **Цахим сургалт:**

Онлайн болон цахим хичээлийг 26 сургуулийн 17422 сурагч, 36 цэцэрлэгийн 6979 хүүхдэд зохион байгуулж байна. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын цахим хичээлийн хамрагдалт 80,0-85,0 хувь, цэцэрлэгийн хүүхдийн хамрагдалт 85,0-90,0 хувьтай байна.



Дорнод аймгийн хэмжээнд 4 дүгээр сарын 12-аас хөл хорио тогтоосонтой холбогдуулан ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтнуудад цахим уулзалт хийж, үүрэг чиглэл хүргүүлсэн.

Ерөнхий боловсролын 26 сургуульд “Амжилт” системийг нэвтрүүлэхэд бэлэн болоод байна. Системийн нэвтрүүлэлтийг хийх сургалтыг ерөнхий боловсролын 26 сургуулийн захирал, 48 сургалтын менежер, 855 багшид 5 бүсээр 6 удаагийн сургалт, эцэг эхийн зөвлөлийн гишүүдэд 1 сургалтыг “Амжилт” системийн ажилтан, Боловсролын албатай хамтран зохион байгуулж, сургуулиуд хэрэглэж эхлээд байна.

Монгол хэл, бичгийн 75 багшид сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх сургалтыг Үндэсний зөвлөх, сургагч багштай хамтран зохион байгуулсан.

Сургалтын үр дүнд монгол хэлний агуулгын хүнд сэдэв болон суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх, монгол хэлний чанарыг дээшлүүлэх идэвхтэй сургалтын арга зүйд суралцсан.

### **Сургалт, зөвлөмж дэмжлэг:**

Сургууль, цэцэрлэг бүсчилсэн зохион байгуулалтаар хүүхэд хамгаалал, коронавируст (Covid-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж, чиглэл, нөлөөллийн үйл ажиллагаагааг Боловсрол, соёл урлагийн газрын цахим хуудсаар дамжуулан өдөр бүр олон эцэг, эх, асран хамгаалагч, хүүхэд, багачууд болон олон нийтэд хүргэж байна.

“Зөвлөх баг”-ийн ажлын гараа “Зөвлөх багшийн манлайлал” онлайн хэлэлцүүлгээр амжилттай эхэллээ. Хэлэлцүүлэгт 71 оролцогч холбогдон оролцлоо. Хэлэлцүүлгийн чиглэлүүд:

- Зөвлөх багш бүр хувийн манлайллаа хэрэгжүүлэн ажиллаж буй туршлага,
- Цаашид хэрхэн хамтран ажиллах чиглэл, шинэ санааг дэвшүүлэх,
- “Зөвлөх багшийн тэргүүн туршлага” түгээн дэлгэрүүлэх танилцуулга хийх

Эрсдэлд нөхцөлд байгаа Цагаан-Овоо, Хөлөнбуйр, Дашбалбар сумын багш, ажилтан, албан хаагчдад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх арга зүйн сургалт, уулзалтыг 2 удаа зохион байгуулж, тэдэнд шаардлагатай ариутгал, халдваргүйтгэл, дархлаа, стрессийг удирдах менежмент, сэтгэл зүйн зөвлөгөө зэрэг мэдээлэл өглөө.

### **Эрдэм шинжилгээний бага хурал:**

Орчин цагийн боловсролын байгууллага үүсэн байгуулагдсны 100 жилийн ойг тохиолдуулан сургуулийн нийгмийн ажилтан, нийгмийн ухааны багш нарын дунд заах аргын нэгдлийн болон арга зүйн ажлын үр дүн, бодит байдлын сайн туршлагаа түгээх, илтгэл бичих, мэдлэг, ур чадварыг ахиулах чиглэлээр 2 үе шаттай зохион байгууллаа.

Онол, практикийн бага хурлын 1 дүгээр шатанд нийгмийн ухааны 41 багш, 19 нийгмийн ажилтан оролцож бүс бүсээрээ өөрсдийн илтгэлээ хэлэлцүүлж, бүсээсээ шалгарсан нэг багш, нэг нийгмийн ажилтны илтгэлийг бүсийн хурлын тэмдэглэлтэй хамт 2 шатанд нийт 10 оролцогч шалгарч илтгэлээ танилцуулсан.

### **Ололт, амжилт:**

Улсын хэмжээнд “Дэлхийн том хичээл ТХБ” арга зүйн шинэ санаа, шийдэл бүхий хичээлийн жишээ, багшлахуйн сайн туршлагаар Дорнод аймгаас оролцсон хичээлүүдээс сургуулийн өмнөх боловсрол, бага, суурь, бүрэн дунд боловсролын 4 хичээл шалгарлаа.

Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 4 дүгээр шатны төслийн хэрэгжилт, үр дүн, сургамжийг дүгнэх, 5 дугаар шатны гарын авлагыг танилцуулах, цаашдын алхмуудыг хэлэлцэх зорилгоор 2021 оны 4 дүгээр сарын 15-ны 09-17 цагт “Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 5 дугаар шат танилцуулах” онлайн сургалтыг амжилттай зохион байгуулав.

Аймгийн ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын багш, удирдах ажилтнуудын дунд “Мэдээллийн технологийн хэрэглээ 2021” онлайн уралдаан зохион байгуулж, 600 хүн оролцсон.

Дорнод аймгийн ерөнхий боловсролын сургуульд дутагдалтай байгаа багш мэргэжлийн оюутнуудтай холбоо тогтоох, ажил хэргийн уулзалт зохион байгуулах, хамтран ажиллах, санал солилцох, багш мэргэжлийн үнэ цэнэ, нэр хүндийг өсгөхөд хувь нэмэр оруулах зорилгоор “Ажил олгогч төгсөгчид”-ийн онлайн уулзалтыг зохион байгуулав. Уг онлайн хуралд МУБИС-ийн бүрэлдэхүүн сургууль БУС, НХУС, ДУТС, БС, ДИС-ийн Бага боловсрол, монгол хэл, математик, англи хэл, дизайн технологи, хөгжим, байгалийн ухаан, биеийн тамирын багш мэргэжлээр төгсөх ангийн 40 оюутан, ерөнхий боловсролын сургуулийн 20 захирал оролцсон.

### **Бэлэн байдал, эргүүл хяналт:**

Улс орон даяар Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Чойбалсан хотын Тусгаар тогтнолын талбай, “Найрамдал” цэцэрлэгт хүрээлэн, гудамж талбай, тоглоомын талбай зэрэг газраар эргүүл, хяналтаар ерөнхий боловсролын сургуулийн 172 багш сайн дураар ажиллав.

Мөн аймгийн төв Хэрлэн сумын хэмжээнд 359, хөдөө сумдад 527 боловсролын байгууллагын багш, албан хаагчид эргүүл, хяналтад ажиллав.

### **Нөлөөллийн үйл ажиллагаа:**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн салбар зөвлөлийн төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу

ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн дунд “Цахим орчин Хүүхэд хамгаалал” сэдэвт нөлөөллийн үйл ажиллагааг сарын хугацаанд зохион байгууллаа.

Нөлөөллийн үйл ажиллагааны хүрээнд хүүхэд, хамгааллын ойлголт, мэдээллийг иргэд олон нийтэд шторк, зурагт хуудас, сургалт мэдээллээр дамжуулан хүргэлээ.

### **Соёлын үйл ажиллагаа:**

Соёлын яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын Мэдээллийн технологи, статистикийн хэлтсээс ирүүлсэн аймгийн соёл урлагийн салбарын ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулах судалгаанд тус салбарын 17 байгууллагын 150 орчим албан хаагчдыг хамруулсан.

Монгол Улсын Консерваторийн (хуучнаар Хөгжим Бүжгийн Коллеж) Дуулаачийн тэнхимээс санаачлан ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Алтан тайз руу” дууны анхдугаар цахим уралдааны удирдамж, мэдээллийг хөгжмийн багш нарт хүргэж, сурагчдын оролцуулах тухай хөгжмийн багш нарт чиглэл өгсөн.

Соёлын яаманд аймгийн 13 сумдын Соёлын төвийн цахим хуудас болон бүтэц, байгууллагын түүхэн товчоон зэргийг нэгтэн хүргүүлсэн.

“Хүүхдэд хөгжмийн боловсрол олгох нь” төслийн сургалтын зохион байгуулалтын талаар ерөнхий боловсролын сургуулиудын удирдлагуудад танилцуулга, мэдээлэл өгсөн. Төслийн хөгжмийн зэвсэгийн худалдан авалт хийх зорилгоор хөгжмийн зэмсэг үйлдвэрлэдэг, худалдаа эрхэлдэг 3 ААН-ийн саналыг нэгтгэн дүгнэлт гарган “Эгшиглэн магнай” ХХК-ийг сонгон нэхэмжлэх гэрээг баталгаажуулж, төсвийн нягтланд шилжүүлж өгсөн.

Дашбалбар сумын орон нутгийн төсвөөр баригдаж байгаа Буриад өв соёлын цогцолбор барилга болон тухайн байгууллагын ажлын чиг үүргийн талаар Соёлын төвд Соёлын үндэсний төвөөс мэргэжлийн зөвлөмж хүргүүлээ.

Хүүхдийн номын ордон, аймгийн Номын сан хамтарч зохион байгуулсан номын санчдын сургалтад сумдын Соёлын төвийн номын санчдыг хамруулав.

Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулсан судалгаанд хөгжмийн боловсрол мэргэжлийн зөвлөлийн дарга, гишүүд, багш нарыг хамруулав.

**Гурав. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар**

**“Өргөдөл, гомдол”-ын шийдвэрлэлтийн мэдээлэл:**

Тайлант сард хүүхэд, гэр бүлийн эрх зөрчигдсөн асуудлаар өргөдөл, гомдол, хүсэлт, хүүхдийн тусламжийн 108 утсаар нийт 15 дуудлага, өргөдлийг хүлээн авч, хуулийн дагуу хамгааллын хариу үйлчилгээг үзүүлж, 85 хувийг нь шийдвэрлэсэн. “Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөө”-өөр нийт 12 хүүхэд 5 удаагийн давтамжтай зөвлөгөө, үйлчилгээ аваад байна. “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д 8 хүүхэд, 1 насанд хүрэгчийг хүлээн авч, хамгаалан байрлуулж, аюулгүй байдалд хяналт тавин эрүүл мэнд, сэтгэлзүй, хууль эрх зүйн болон холбон зуучлах, хамгааллын үйлчилгээг шуурхай хүргэсэн. Эрх нь зөрчигдөж, бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон 4 хүүхдийн шүүх хурлын урьдчилсан хэлэлцүүлэгт оролцож, 1 хүүхдийн эрхийг эцэслэн шийдвэрлэж, 5 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр ажиллан хүүхдийн эрхийг хангасан. Мөн Хэрлэн сумын 3 хамтарсан багт зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, кейс хэлэлцүүлгийг Японы Хүүхдийг ивээх сантай хамтран зохион байгуулж, Хүүхдийн эрхийн байцаагчаас хүүхдийн эрхийн 3 зөрчил шалган, гэм буруутай этгээдэд 800,000 төгрөгийн мөнгөн торгууль ногдуулсан.

**Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр:**

Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах” тусламж дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд “Хүүхэд, хамгааллын мэргэжлийн ангийн бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу Хүүхэд, хамгааллын мэргэжлийн ангийн шуурхай штабыг байгуулан 70584455 утсаар дуудлага, мэдээллийг өдөр бүр тогтмол хүлээн авч хариу үйлчилгээг тогтмол үзүүлж байна.

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл 2 удаа 100 хувийн ирцтэйгээр цахимаар хуралдаж, Коронавируст (Covid-19) цар тахлын үед авч хэрэгжүүлэх аймгийн Засаг даргын “Хүүхдийн эрх аюулгүй байдлыг хангах тухай” 2021 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар хэлэлцэж, хүүхдийн аюулгүй байдлыг бүх шатанд анхаарч ажиллах чиглэлээр үүрэг хүлээгчдэд аймгийн Засаг даргын зүгээс шуурхай зөвлөмж, чиглэл өгөв.

Тус хурлаар 3 сумын цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор авч, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээлэлтэй танилцаж, зөвлөлийн 2021 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталж, цаашид сар бүрийн 01-ний өдөр хуралдахаар шийдвэрлэв.

Мөн зөвлөлийн хурлын үеэр “Оролцоод хөгжье” хүүхдийн цахим чуулганыг уялдуулан зохион байгуулан 13 сумын Хүүхдийн төлөө зөвлөлийн дарга, хүүхдийн элч, сумдын нийгмийн ажилтнууд, ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, 13 сумдын хүүхдийн төлөөлөл нийт 150 гаруй хүнийг оролцуулав.

Чуулганд сум бүрээс хүүхдүүдийн төлөөллийг оролцуулан, шийдвэр гаргах түвшинд тэдний санал хүсэлтийг сонсохын зэрэгцээ үндэсний цахим чуулганд Дорнод аймгаа төлөөлөн оролцох сурагчийн илтгэлтэй танилцаж, Дашбалбар сумын Хүүхдийн элч “Хүүхдийн элчийн үүрэгт ажлын Сайн туршлага”-ыг танилцуулан хэлэлцэв.

Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн 3 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дэргэд эцэг эхийн зөвлөл байгуулах чиглэлийг арилжааны банк, цэргийн анги, нэгтгэл, 20-иос дээш ажилтантай сүлжээ дэлгүүр зэрэг нийт 17 газарт хүргүүлж, чиглэл өгснөөр Зэвсэгт хүчний 327 дугаар ангиас 9 хүний бүрэлдэхүүнтэй эцэг эхийн зөвлөлийг байгуулаад байна.

Хүүхдийг зодож шийтгэхийг таслан зогсоох дэлхийн өдрийн хүрээнд сургууль “Хүүхдийн хүмүүжлийн эерэг арга, хүүхэд хамгаалах бодлого, хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлог, эцэг эхийн харилцааны алдаа” сэдвүүдээр цахим сургалтыг үе шаттай зохион байгуулав. Уг сургалтад цэцэрлэгийн багш, эцэг эхчүүд 1520 хүн хамрагдав.

Хүүхдийн эрхийн зөрчил, мэдээлэлтэй холбоотой асуудлаар Баян-Уул суманд хүүхдийн эрхийн улсын байцаагч ажиллаж, хүүхдийн эрхийн чиглэлээр сургалт зохион байгуулан давхардсан тоогоор 240 гаруй багш, эцэг эхчүүдийг хамруулан, урьдчилан сэргийлэх мэдлэг олгосон.

### **Залуучуудын хөгжил оролцооны чиглэлээр:**

Залуучууд хөгжлийн төвөөс “Амьдрах ухааны чадвар олгох 12 модуль сургалт”-ыг цувралаар өсвөр үе, залуучуудад тогтмол зохион байгуулж байна. Тайланд сард 3 байгууллага болон “Dornod volunteers” клубын гишүүдэд “Цахим орчны хэрэглээ”, “Стрессийг зохицуулах нь” сэдвүүдээр онлайн сургалтыг зохион байгуулж, 85 өсвөр үе залуучууд болон эцэг эхчүүд хамруулав.

“Good deeds day” (Сайн үйлсийн өдөр) аяны хүрээнд 6 төрлийн ажлыг төлөвлөн аж ахуйн нэгж, албан байгууллагад удирдамж, албан тоотыг хүргүүлж, байгууллага, гэр бүл, найз нөхдөөрөө нэгдэн нэг өдрийг хүрээлэн буй орчноо сайжруулах, нийтэд ашиг тустай ажил зохион байгуулахыг уриалж, мэдээллийг түгээв. “Гэрээрээ хийх сайн үйлс санаачилга” өрнүүлэх аянд 3 сургуулийн 30 гаруй сурагчид нэгдэн халдвар, хамгааллын дэглэмийг чанад баримтлан амьдарч буй орчин, орцоо цэвэрлэж, сайн санаачилгыг өрнүүлсэн.

Мөн “Тоглоомын талбай цэвэрлэх аян”-ыг өрнүүлэн сайн дураараа нэгдсэн өсвөр үе, залуучууд болон Дорнод аймгийн музей, Мэргэжлийн сургалт,

үйлдвэрлэлийн төвийн нарийн бичгийн ангийн оюутан, залуучууд зэрэг нийт 40 гаруй залуучууд оролцон “Найрамдал” цэцэрлэгт хүрээлэн болон орон сууцны 5 байрны гаднах тоглоомын талбайг цэвэрлэж, аймгийн Эрүүл мэндийн газрын заавар, зөвлөмжийн дагуу ариутгав.

***Дөрөв. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
Нийгмийн даатгалын хэлтэс***

**Нэг. Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлтийн талаар:**

Нийгмийн даатгалын санд 2021 оны 04 дүгээр сард 2201926,5 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2478080,58 мянган төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 108,1 хувиар биелүүлсэн. 2021 оны 04 дүгээр сарын мэдээгээр нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлтийг хүснэгтээр харуулбал:

Нийгмийн даатгалын сангийн орлого /мянган төгрөг/

д/д	Төрөл	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Тэтгэврийн даатгалын санд	1909135.0	2153504.28	112,8
2	Тэтгэмжийн даатгалын санд	144837.5	162652.5	112,3
3	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд	119617.1	133133.8	111,3
4	Ажилгүйдлийн даатгалын санд	28336.9	28790	101,5
	Нийт	2201926.5	2478080.58	112,6

Нийгмийн даатгалын ерөнхий газраас тэтгэврийн санд нийт 2900000,0 мянган төгрөгийн, тэтгэмжийн санд нийт 200000,0 мянган төгрөгийн санхүүжилтийг хүлээн авсан.

2021 оны 04 дүгээр сард нийт 541 ажил олгогч байгууллагын 307,2 сая төгрөг, 1566 сайн дурын даатгуулагчдын 70,3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлээс (Тэтгэврийн даатгалын 8,5 хувь, Эрүүл мэндийн даатгалын 2 хувын шимтгэлээс бусад) тус тус чөлөөлсөн байна.

**Хоёр. Тэтгэвэр тогтоолт, олголтын талаар:**

Аймгийн хэмжээнд 2021 оны 04 дүгээр сард нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын сангаас:

- Өндөр нас 9293,
- Тахир дутуу 2806,
- Тэжээгчээ алдсан 621

- Цэргийн тэтгэвэр 621, нийт 13330 тэтгэвэр авагчдад 5137386,88 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон. 2021 оны 04 дүгээр сард нийт 90 иргэнд шинээр тэтгэвэр тогтоов.

**Гурав. Тэтгэмж олголтын талаар:**

- Хөдөлмөрийн чадвар түр алдсны тэтгэмж 121,
- Жирэмсэн амаржсны тэтгэмж 71,
- Оршуулгын тэтгэмж 29 даатгуулагчид, нийт 150552,54 мянган төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон.

**Дөрөв. Ажилгүйдлийн тэтгэмж олголтын талаар:**

Аймгийн хэмжээнд 2021 оны 04 дүгээр сард нийт 129 даатгуулагчдад 216489,07 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг бодож олгов.

**Тав. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн зардал:**

Уг сангаас 75 тэтгэвэр авагчдад нийт 35002,1 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон байна.

**Зургаа. Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагын чиглэлээр:**

2021 оны 04 дүгээр сарын байдлаар 1004106,8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагатай байна. Үүнээс 238 аж ахуйн нэгж, байгууллагын 752860,10 мянган төгрөг, 27 төсөвт байгууллагын 251246,70 мянган төгрөгийн өр, авлага үүсгэсэн байна.

**Долоо.Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаа:**

Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс 3 удаа хуралдаж, 247 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөр зохицуулалтын асуудлыг шийдвэрлэснээс 5 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалсан, 216 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгасан, 19 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоосон байна.

Коронавируст халдвар (Covid-19)-ын цар тахал ихэссэнтэй холбоотойгоор Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын хурлыг цахимаар зохион байгуулж байна. 2021 оны 04 дүгээр сард нийт 9 иргэний амбулаторийн картыг магадлаж, шинжилгээний бүрдэл дутуу, оношийн үндэслэл хангалтгүй, заалт тохирохгүй шалтгааны улмаас 6 картыг буцаах арга хэмжээ авав.

Түүнчлэн комиссын хурлаар орж буй иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох үндэслэлд хяналт тавьж, онош заалт тохирохгүй, оношийн

үндэслэл хангалтгүй, шинжилгээний бүрдэл дутуу зэрэг шалтгааны улмаас 6 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг түдгэлзүүлэх арга хэмжээ авлаа.

**Ес. Дотоод ажил, сургалт сурталчилгаа, олон нийттэй харилцах чиглэлээр:**

2021 оны 04 дүгээр сард үдийн цайны цагаар 91 иргэнд, 1591 хүнд угтах үйлчилгээг үзүүлсэн. Түүнчлэн нээлттэй утас 70585955 дугаарт хандсан 1218 иргэн даатгуулагчид зөвлөгөө, мэдээлэл өгсөн.

Нийгмийн даатгалын архиваас 40 даатгуулагчид лавлагаа олгож, бусад 5 аймаг, дүүргийн 5 иргэнд лавлагаа олгож тэдний нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрхийг баталгаажууллаа.

Мөн 2006 оноос хойших “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт” програмыг ашиглаж, дахин давтагдашгүй тоон өгөгдөл бүхий QR-кодтой лавлагааг 26 иргэнд түргэн шуурхай чирэгдэлгүй олголоо.

Иргэд, даатгуулагчидад нийгмийн даатгалын сайн дурын даатгалын талаарх мэдээллийг цахим хуудас болон орон нутгийн “Мижиг”, “Дорнод” телевизүүдээр хүргэж байна.

Коронавируст халдвар (Covid-19)-ын цар тахал ихэссэнтэй холбогдуулан аймгийн Онцгой комиссийн шийдвэрийн дагуу 2021 оны 04 дүгээр сарын 10-аас 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл аймгийн хэмжээнд “0” зогсолт хийсэнтэй холбоотойгоор өдөрт 2 ажилтан ажиллахаар төлөвлөгөө боловсруулан ажилласан.

Мөн 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нийгмийн даатгалын болон тэтгэврийн дэвтрийг цахимд шилжиж байгаатай холбоотой 4 дүгээр сард 534 иргэд, даатгуулагчийн нийгмийн даатгалын аппликэйшнийг баталгаажуулсан байна.



**Тав. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар**

**Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ:**

**Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэний мэдээ:**

Тайлант сард 35 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс 95 сул чөлөөтэй ажлын байрны захиалга ирүүлсний дагуу цахим хуудас болон хэвлэмэл хуудас, утсаар холбогдож, 78 иргэнд санал болгож, 58 иргэнийг ажлын байранд зуучилсан.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа хязгаарлагдсан, гадаадын хөрөнгө оруулалттай ажил олгогчдын гадаадын ажиллах хүч, мэргэжилтний хөдөлмөр эрхлэлт хаагдсан зэрэг шалтгаанаас болж, ажил олгогч аж ахуйн нэгж бүрэн хүчин чадлаараа ажиллаагүйтэй холбоотойгоор хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний үзүүлэлт буурахад нөлөөлж байна.

Ажилд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл уул уурхай 2, бөөний болон жижиглэн худалдаа 20, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт 36 иргэн тус тус зуучлагдсан байна.

**Бүртгэлтэй ажил хайгч, ажилгүй иргэний хөдөлгөөний мэдээ:**

Бүртгэл, мэдээллийн санд 949 ажил хайгч иргэн бүртгэлтэй байна. Үүнээс эмэгтэй 420. Ажил хайж буй иргэдийн боловсролын түвшингээр авч үзвэл бага боловсролтой, боловсролгүй 32, суурь боловсролтой 49, хамгийн их буюу 562 бүрэн дунд, техникийн тусгай дунд боловсролтой иргэд эзэлж байна.

**Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө, мэдээллээр хангах үйлчилгээ:**

Ажил хайгч, ажил олоход хүндрэлтэй, их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль төгссөн иргэдэд бүлгийн зөвлөгөө өгөх чиглэлээр “Эртэч уулзалт”-ыг 3 удаа ажил олгогч болон ажил хайгч 15 иргэн, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 100 сурагч, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын 80 сурагчдад тус тус зохион байгуулж, нийт 195 иргэнийг хамруулан зөвлөгөө, мэдээлэл өгсөн.

### **Гадаадын хөдөлмөр эрхлэлт:**

“Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах тухай” хуулийн хуулийн 8 дугаар зүйлд гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулах байгууллага нь уг хуулийн 8.2.8-д зааснаар тухайн байгууллагад гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулах шаардлага, хэрэгцээний тухай орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн албаны саналыг авсан байна гэж заасны дагуу “Steppe Gold” ХХК-аас 1 гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг орон нутагт хөдөлмөр эрхлүүлэх хүсэлт гаргаснаас 1 гадаад иргэнийг тухайн аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхлэхийг дэмжиж холбогдох саналыг хүргүүлсэн.

### **Төсөл хөтөлбөрийн хүрээнд:**

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын 2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн А/49 дүгээр тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийг 2021-2022 онд зохион байгуулах нэгдсэн удирдамж батлагдсан. Үүнтэй холбогдуулан аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлд хөтөлбөрүүдийн танилцуулга, мэдээлэл хүргэхээр бэлтгээд байна.

“Залуучуудын хөдөлмөр эрхлэлт ба залуучуудын хөгжлийн чиг хандлага-2021” онлайн уулзалтыг “SMS стартап” сургалтын төвөөс зохион байгуулж, 21 аймаг 9 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллагын удирдлагууд болон залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтнүүд оролцлоо.

Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд зохион байгуулж буй “Ажил хайгч залуучуудад хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ хийх, хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө гаргах үйлчилгээ үзүүлэхэд <https://yesdesk.mn> веб платформ ашиглах” цахим сургалтад хөдөлмөрийн хувийн биржүүд болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтнүүд хамрагдлаа.

Хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ, Хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө гаргах үйлчилгээг веб ашиглан залуучуудад хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх болон ажил хайгч залуучуудыг хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх чадварын хувьд “боломжтой”, “дунд зэрэг”, “боломж багатай” гэж ангилна. Хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх “боломжтой” гэсэн үнэлгээ авсан залуучуудыг тохирох ажилд зуучилна. “Дунд зэрэг”, “бага” гэсэн үнэлгээ авсан залуучуудад хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулж, хувь хүний ур чадвар, хэрэгцээнд тулгуурлан дэмжлэг үзүүлсэний дараа ажилд зуучилна нэгдсэн ойлголтод хүрсэн. (Сургалтад хамруулах, ганцаарчилсан зөвлөгөө өгөх гэх мэт)

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг, дунд үйлдвэрийн газар, “Экспорт олон улсын худалдааны төв” ТББ-тай хамтран дотоодын үйлдвэр эрхлэгчдийг төрийн худалдан авалтаар дэмжих, бараа бүтээгдэхүүнийг танилцуулах зорилгоор “Төрийн худалдан авалт-Үндэсний үйлдвэрлэл” уламжлалт цахим үзэсгэлэнд хөдөлмөр эрхлэлтийн жижиг зээл болон санхүүгийн дэмжлэг авсан 8 иргэнийг оролцууллаа.

### **Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр:**

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны нээлтийн ажиллагааг 14 сумын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөл, аймгийн төвийн 11 багийн ажлын албатай онлайнаар зохион байгуулж, сарын аяны хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг танилцууллаа.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян 2021” арга хэмжээний хүрээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, ХБНГУ-ын Физик техникийн хүрээлэн (ФТХ)-тэй хамтран “Тоосоор үүсгэгддэг мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэлт” сэдэвт цахим симпозиум арга хэмжээнд хамрагдсан. Сургалтаар тоосны шалтгаант мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэхэд онцгой анхаарах, тоосны өөрчлөлтийг зохицуулах стандартын ач холбогдол, үр дүнг таниулах, олон улсын туршлагыг сонсох, аж ахуйн нэгж байгууллагуудад стандарт хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал мөн сайн туршлагыг талаарх мэдээллийг солилцов.

Хөдөлмөр Нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн Үндэсний төвөөс зохион байгуулж буй “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чадавхийг бэхжүүлэх нь” сэдэвт сургалтад аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөл болон сумдын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөлийн гишүүд оролцсон.

Сургалтаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар төрөөс баримталж буй бодлого, цаашдын зорилт, бодлогын хэрэгжилт, үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх дүрмийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал, мэргэжлээс шалтгаалсан өвчин, ажилтай холбоотой эрүүл мэндийн асуудал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн соёлыг бий болгоход ААНБ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөлийг үүрэг, оролцоо талаар мэдээлэл өгсөн.

Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөл Политехник коллежийн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн мэргэжлийн багтай хамтран хүүхдийг эрүүл аюулгүй орчинд сурч, хөгжих бололцоог бүрдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн олон улсын стандартыг хэрэгжүүлэхээр болоод байна.

Иймд дээрх ажлын хүрээнд Хэрлэн сумын болон хөдөөгийн сумын ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадаад, дотоод орчинд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн “эрсдэлийн үнэлгээ”-г хийхээр аймгийн Засаг даргын орлогч, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөлийн дарга Ш.Ёл, Боловсрол, соёл урлагийн газрын дарга А.Нансалмаа, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний дарга Н.Мөнхгэрэл нар Дорнод аймгийн боловсролын салбарын удирдлагуудтай цахим хурлыг зохион байгуулж, эрсдэлийн үнэлгээг хэрхэн зохион байгуулах талаар санал мэдээлэл солилцлоо.

#### **Нийгмийн халамжийн чиглэлээр:**

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 1788 иргэн хамрагдаж, 501,9 сая төгрөг, асаргааны тэтгэмжид 1229 иргэн хамрагдаж, 110,6 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмжид 259 иргэн хамрагдаж, 68,9 сая төгрөг, жирэмсэн эхийн тэтгэмжид 639 иргэн хамрагдаж, 23,9 сая төгрөг, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжид 3901 иргэн хамрагдаж, 191,7 сая төгрөг, өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмжид 7 иргэн хамрагдаж, 2,6 сая төгрөг, ахмад настанд олгох тусламж, хөнгөлөлтөд 2 иргэн хамрагдаж, 245,0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тусламж, хөнгөлөлтөд 167 иргэн хамрагдаж, 4,8 сая төгрөг, эхийн алдар одон 3 иргэнд 300,0 мянган төгрөг, нийт 7995 иргэнд 904,9 сая төгрөг зарцуулсан байна.

#### **Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чиглэлээр:**

Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох зорилгоор амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлаар 2021 онд хэлэлцэгдэж, ирсэн бүлгийн төслийн явцтай танилцаж, нөхцөл байдлыг үнэлж дүгнэн 2 бүлгийн төсөлд санхүүгийн дэмжлэг үзүүлж, 2,0 сая төгрөгийг зарцуулсан. Тус бүлгүүд үйл ажиллагаагаа идэвхжүүлээд байна.

#### **Хүнсний эрхийн бичгийн чиглэлээр:**

Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 2228 өрхийн 6535 том хүн, 5961 хүүхэд, нийт 12496 иргэн хамрагдаж, 152,2 сая төгрөгийн санхүүжилт зарцуулсан байна. Үүнээс Хэрлэн суманд 1758 өрхийн 5212 том хүн, 4702 хүүхэд, нийт 9914 иргэнд 121,0 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, 10 нэр, төрлийн хүнсний бүтээгдэхүүний дэмжлэг авсан байна.

Хүнсний эрхийн бичгийн цахим үйлчилгээг гэрээт дэлгүүрээр бус иргэн НӨАТ төлдөг хүссэн дэлгүүрээс карт уншуулан авах үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор иргэдийн картыг пин кодтой болгох ажлыг эхлүүлсэн.

#### **Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн чиглэлээр:**

Өрхийн нэгдсэн мэдээллийн санд 2021 оны 04 дүгээр сард 60 өргөдөл, гомдол бүртгэгдсэн байна. Үүнээс 83,3 хувь нь буюу 50 өргөдлийг шийдвэрлэсэн. Мөн тус сард шинэ төрсөн хүүхдийг “Хүүхдийн мөнгөн тэтгэмж”-д хамруулах 149 өрх, иргэн хамрагдах хүсэлтийг хүлээн авч, програмд шинээр бүртгэсэн.

Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдаж, тулгалтаар мэдээлэл зөрүүтэй гарсан 32 өрхтэй холбогдож, шаардлагатай баримтыг авчран зөрүүг засварлуулах талаар мэдээлэл өгсөн. Мэдээллийн зөрүүг холбогдох баримтаар засварлуулсан 7 өрхийн оноог бодуулсан.

#### **Ахмад настны чиглэлээр:**

Ахмад настнуудын дархлаажуулалт эхэлж байгаатай холбогдуулан аймгийн хэмжээнд амьдарч байгаа ахмад настнуудын судалгааг сум, баг, нас, хүйсээр гаргаж хүргүүлсэн.

Байгууллагын “Эцэг,эхийн зөвлөл”-өөс гэр бүлийн өдрийг угтаж, цар тахалын нөхцөл байдал хүндэрч, цэцэрлэг, сургууль ажиллахгүй байгаатай холбогдуулан хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх, эерэг зуршил бий болгох сургалтыг цахим хэлбэрээр зохион байгууллаа. Сургалтыг байгууллагын ажилтан, албан хаагчдын гэр бүл, үр хүүхдүүдийг хамруулан зохион байгуулсан.

#### **Хөгжлийн бэрхшээлтэй иргэний чиглэлээр:**

Энэ сард Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 1 удаа хуралдаж, 6 хүүхдийн асуудал хэлэлцэн 2 хүүхдийг байнгын асаргааны тэтгэмжид шинээр оруулж, 4 хүүхдийн байнгын асаргааг сунгасан.

Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд “Эрүүл идэвхтэй амьдрал” арга хэмжээг хэрэгжүүлэх 2021-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналыг салбар комиссын гишүүдээс авч хүргүүлсэн.

Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих салбар зөвлөлийн 2021 онд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулах саналыг Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлсэн.

### **Зүүн бүсийн ахмад настны асрамж, үйлчилгээний хүрээнд:**

Зүүн бүсийн ахмад настны асрамж, үйлчилгээний төвд Коронавирусын (Covid-19) халдвар тархалтаас урьдчилан сэргийлж, орчны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг зааврын дагуу тогтмол хийж, ахмадуудад маск зүүлгэж, гарын ариун цэврийг сайтар сахиулж, гар ариутгагчийг тогтмол хэрэглүүлэн, эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр үйлчилж байна.

Зүүн бүсийн ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн тогооч, асрагч, галч нарыг 04 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн цар тахалаас урьдчилан сэргийлэх зорилгоор ээлжээр ажиллуулж байна. Ажилтан нь 5 хоног ажиллаад, 5 хоног амрах зохицуулалтыг хийсэн. Ингэснээр халдвар бүртгэгдсэн тохиолдолд бүх ажилтан халдвар тусах эрсдлээс сэргийлэх юм.

### **Нээлттэй утас: 70582255 дугаарт ирсэн дуудлагын мэдээлэл:**

Нээлттэй утас: 70582255 дугаарт 4 дүгээр сард 1578 дуудлага бүртгэгдсэн. Үүнээс: Хөдөлмөрийн хэлтэстэй холбоотой 25, Нийгмийн халамжийн хэлтэстэй холбоотой 1542, бусад 11 дуудлага ирсэн. Дуудлагын 80 орчим хувь нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн санхүүжилтийн олголтын талаарх тодруулга байв. Иргэдээс нийтлэг асууж буй тодруулгаар 7 хоног бүр постер бэлтгэн цахим хуудсанд байршуулан иргэдэд хүргэж байна.

### **Бусад ажил, үйлчилгээ:**

Төрийн албан хаагчийн сургалт, хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсны дагуу албан хаагчдыг чадавхижуулах сургалтыг 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 3 хоногийн хугацаанд цахим хэлбэрээр зохион байгууллаа. “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, “Бодлогын баримт бичгийг тайлагнах арга зүй” 2 сэдвээр нийт 6 цагийн сургалтыг цахимаар зохион байгуулсан. Сургалтад төрийн захиргааны 32 албан хаагч оролцов.

Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийн эргэлтийг дэмжих зорилгоор иргэн бүрт 300 мянган төгрөгийн нэг удаагийн тусламжийг олгохоор шийдвэрлэсэн.

Олголтын хүрээнд дансгүй болон нэг удаагийн тусламж дэмжлэгийг аваагүй 3418 иргэдийн жагсаалт Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас тус газарт ирүүлсэн. Жагсаалтын дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтнүүд болон Хэрлэн сумын багийн ажлын албатай хамтран иргэдийг дансжуулах ажлыг 04 дүгээр сарын 28-30-ны өдөр зохион байгуулсан.

Хамтын ажиллагааны хүрээнд ХААН банк, Хас банк, Төрийн банк руу жагсаалтыг хүргүүлэн данстай иргэдийн мэдээллийг авч, тус банкнуудад дансгүй үйлчлүүлэгчидтэй утсаар холбогдон 2662 иргэнийг дансыг тодорхой болгон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлсэн.

Нийт дансгүй 756 иргэн байгаагаас гадаадад 11, хориход 14, цэрэгт 2, нас барсан 5 иргэн тус тус байна.

**Зургаа. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг**  
**Эрүүл мэндийн газар:**

Оны эхний 04 сарын байдлаар 576 эх амаржиж, 582 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс төрөлт 118 тохиолдлоор буурсан, 128 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор бага, хүн амын цэвэр өсөлт 5,5 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 1,6 промилиор буурсан, амбулаториор 130943 хүнд үзлэг хийсэн нь нэг иргэн 1,6 удаа үзүүлсэн, 5375 иргэн хэвтэн эмчлүүлсэн байна.

Төрийн өмчийн 18 эмнэлэг, хувийн хэвшлийн 28 эмнэлэг, эмийн сан 29, нийт 75 газрын үйл ажиллагааны мэдээг нэгтгэн, дүгнэлт хийж, 5 жилийн дундаж үзүүлэлт болон өмнөх оны мөн үетэй харьцуулан 24 нүүр бүхий эрүүл мэндийн болон эмнэлгийн статистик эмхэтгэл бэлтгэн сар бүрийн 5-ны өдөр холбогдох байгууллагын удирдлага, мэргэжилтнүүд, мэдээлэл хэрэглэгчдийг мэдээллээр хангасан.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 139 дугаар тушаалын дагуу 7 хоног бүрийн Мягмар гарагт улсын 17 байгууллагаас эх, хүүхдийн мэдээг [tandalt.ehemut.mn](http://tandalt.ehemut.mn) цахим хаягаар авч, тогтмол хянан ажиллаж байна.

Эмчлэх, сувилах, эм барих мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан 8 эмнэлгийн мэргэжилтний материалыг бүрдүүлэн эрүүл мэндийн хөгжлийн төвд, олон жил үр бүтээлтэй тогтвор суурьшилтай ажилласан, коронавирус (Covid-19) цар тахлын үед онцгой идэвхтэй ажилласан 15 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг төрийн шагналд нэр дэвшүүлэн, хамт олны хурлаар хэлэлцүүлж, ажил байдлын тодорхойлолтыг бүрдүүлэн холбогдох газарт хүргүүлсэн.

Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 2021 онд шаардлагатай жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгсэл, олон найрлагат бичил тэжээл нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 3 удаа зохион байгуулж, нийлүүлэлтийг хийсэн.

Эрүүл мэндийн байгууллагуудад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс 8 байгууллагын үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийж, олгох, сунгах, байршлын өөрчлөлт болон үйл ажиллагааны чиглэлийн өөрчлөлтийг комиссын хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн.

Коронавируст (Covid-19) халдварын ойрын болон дам хавьтлыг илрүүлэх, сайн дурын тандалтын шинжилгээ авах Явуулын шинжилгээний 4 багийг ажиллуулж, тайлант хугацаанд 1993 иргэнийг шинжилгээнд хамруулсан.

Дорнод аймагт 2021 оны 04 дүгээр сарын 06-нд коронавируст (Covid-19) халдварын эхний батлагдсан тохиолдол бүртгэгдэж, 4 дүгээр сард нийт 44 тохиолдол батлагдан 16 иргэн эмчлэгдэж гарсан, нас баралт бүртгэгдээгүй.

Улаанбаатар хот болон бусад аймгуудаас 2021 оны 04 дүгээр сарын 01-30-ны өдрүүдэд Хөлөнбуйр сумын постоор Дорнод аймаг руу 818 тээврийн хэрэгсэл, 1421 зорчигч орж, үүнээс 435 зорчигч 24 цагт багтаж буцсан байна. Түргэвчилсэн тестээр 1071 зорчигчоос шинжилгээ авсан. Гэрийн ажиглалтанд 986 иргэн хянагдаж, ПГУ давтан шинжилгээ өгч, гэрийн ажиглалтаас гарсан байна. Тусгаарлан ажиглах байранд 634 иргэн хянагдаж гарсан.

Хүн амыг коронавируст (Covid-19) халдварын эсрэг дархлаажуулах ажлын хүрээнд ХӨСҮТ-ийн төв агуулахаас БНХАУ-ын Синаформ үйлдвэрийн Вероцилл вакциныг 6 удаа 66453 мянган хүн тунг татан авч, 1 дүгээр тунд 38269 иргэн хамрагдан 70,7 хувьтай, 2 дугаар тунд 6951 иргэн хамрагдаж, 12,3 хувьтай, өссөн дүнгээр 45220 иргэнийг вакцинжуултад хамруулаад байна. Аймгийн хэмжээнд байнгын 18, түр 6, явууллын 18 цэгт 156 эмч, эмнэлгийн мэргэжилтэн вакцинжуулалтын үйл ажиллагаанд оролцож байна.

Монгол Улсын Засгын газрын 2001 оны 224 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны ажлын тухай гэрээ бүхий орон нутгын хоёр телевизээр “Мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр зөвлөмж, мэдээллийг иргэдэд хүргэсэн.

### Зургаа. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР


#### ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:

#### МАЛ АЖ АХУЙ:

#### Хаваржилтын бэлтгэл ажлын талаар:

Аймгийн хэмжээнд 2020 оны жилийн эцэст 5650 малчин өрхөд 2,749,027 толгой мал буюу хонин толгойд шилжүүлснээр 6.1 сая толгой мал хаваржиж байна. Өмнөх онтой харьцуулахад 83344 толгой буюу 4,3 хувиар өссөн дүнтэй байна.

2020 онд нийт 1,233,963 толгой хээлтэгч мал тоолуулснаас 2021 онд 1,043,356 толгой





буюу нийт хээлтэгчийн 84.5 хувь нь төллөх төлөвлөгөөтэй байна.

### Төллөсөн хээлтэгч:

№	Төрөл	Нийт хээлтэгч	Төллөх хээлтэгч	Төллөсөн хээлтэгч	Хувь
1	Ингэ	2378	951	550	57.8
2	Гүү	106269	88203	17,300	19.6
3	Үнээ	115832	96141	26,662	27.7
4	Эм хонь	628618	534325	287,875	57.3
5	Эм ямаа	380866	323736	140,070	43.2
<b>Нийт дүн</b>		<b>1.233.963</b>	<b>1.043.356</b>	<b>472,457</b>	<b>45.3</b>


**Төл бойжилт:** 1,043,356 толгой төллөх хээлтэгчээс 472,457 толгой буюу 45.3 хувь нь төллөж 1525 төлийн хорогдолтой буюу 99.7 хувь нь эсэн мэнд бойжиж байна.

№	Төрөл	Төллөсөн хээлтэгч	Гарсан төл	Хувь	Төлийн хорогдол	Хорогдлын хувь	Бойжиж буй төл	Хувь
1	Ботго	550	550	100	3	0.5	547	99.4
2	Унага	17300	17300	100	71	0.4	17229	99.5
3	Тугал	26662	26662	100	136	0.5	26526	99.4
4	Хурга	287875	289085	100.4	590	0.2	288495	99.7
5	Ишиг	140070	141777	101.2	725	0.5	141052	99.4
<b>Нийт дүн</b>		<b>472457</b>	<b>475,374</b>	<b>100.6</b>	<b>1525</b>	<b>0.3</b>	<b>473849</b>	<b>99.7</b>

**Том малын зүй бус хорогдол:** Том малын зүй бус хорогдол 4412 толгой буюу нийт малын 0,1 хувийг эзлэж байна.

Үүнээс: Адуу 160 толгой буюу 0.04 хувь, үхэр 523 толгой буюу 0.1 хувь, хонь 1694 толгой буюу 0.1 хувь, ямаа 2035 толгой буюу 0.2 хувь мал хорогдсон байна.

№	Төрөл	Нийт мал	Том малын зүй бус хорогдол
1	Тэмээ	6217	0
2	Адуу	324105	160
3	Үхэр	305044	523
4	Хонь	1302873	1694
5	Ямаа	810788	2035
<b>Нийт</b>		<b>2749027</b>	<b>4412</b>



### Аймаг, сумын аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийн зарцуулалт, үлдэгдэл:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 19 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2020-2021 оны өвөлжилт, 2021 оны хаваржилтын бэлтгэл хангах, байгалийн эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг шуурхай зохион байгуулах 02 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрөл	Бэлтгэсэн /тн/		Зарцуулсан /тн/		Үлдэгдэл /тн/			
	Өвс	Тэжээл	Өвс	Тэжээл	Өвс	Хувь	Тэжээл	Хувь

Аймгийн аюулгүйн нөөц	199.7	53.8	8.3	34.3	191.4	<b>95.8</b>	19.5	<b>36.2</b>
Сумын аюулгүйн нөөц	1412.6	363.8	1147.4	323.5	265.2	<b>18.7</b>	40.3	<b>11</b>
Малчдын түвшинд бэлтгэсэн	92206	333.8	85179.8	317.7	7026	<b>7.6</b>	16.1	<b>4.8</b>


**Аймгийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээл борлуулалт:** Аймгийн аюулгүйн нөөцийн өвс 8.3 тонн, хивэг 34.3 тонныг борлуулаад байна.

№	Нийлүүлсэн ААН, байгууллага	Малын тэжээлийн нэр төрөл	Хэмжээ /боодол/	Хэмжээ /тн/	Борлогдсон хэмжээ /тн/	Үлдэгдэл /тн/	Борлуулж буй үнэ
1	"Сарнайн туяа" ХХК	Байгалийн хадлангийн өвс	8630	172.6	8.3	164.3	<b>3300</b>
2	"Дорнод гурил" ХХК	Хивэг	1373	34.3	34.3	0	<b>11000</b>
3	"Дорнын уудам тал" ХХК	Ногоон тэжээл	1085	27.1	0	27,1	<b>9500</b>
4	"Тасу Бридж" ХХК	Жижиглэсэн ногоон тэжээл	780	19.5	0	19,5	<b>13000</b>
<b>НИЙТ</b>			<b>Өвс</b>	<b>199.7</b>	<b>8.3</b>	<b>191.4</b>	-
			<b>Тэжээл</b>	<b>53.8</b>	<b>34.3</b>	<b>19.5</b>	-

**Аймгийн аюулгүйн нөөцийн өвсийг Хэрлэн сумын малчин иргэдэд үнэ чөлөөлж олгохоор шийдвэрлэв:** Аймгийн



Засаг даргын 2021 оны "Өвсний үнэ чөлөөлх тухай" А/ 178 дугаар захирамжаар аймгийн аюулгүйн нөөцийн 2018 онд бэлтгэсэн 8223 боодол буюу 164,4 тонн өвсийг коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үеийн хязгаарлалтын дэглэмтэй холбогдуулан өвс, тэжээл хангах боломжгүй байсан Хэрлэн сумын малчин иргэдэд үнэ чөлөөлөн олгох шийдвэр гарсан.

Аюулгүйн нөөцийн өвсийг Хэрлэн сумтай хамтран малчдад олгох ажил хорио цээрийн дэглэмтэй байгаа тул түр хугацаагаар хойшлогдоод байна.



**Отроор өвөлжиж байгаа малын судалгаа:** Аймгийн хэмжээнд 2020-2021 онд нийт 98 малчин өрхийн 72,724 толгой мал отроор ирсэн байна.

Матад сумын 35 өрхийн 32,629 толгой мал өөрийн орон нутагтаа буцсан. Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дундговь, Төв, Сүхбаатар, Хэнтий, Өвөрхангай, Улаанбаатар нийт нийслэл, 9 аймгийн 63 өрхийн 40,095 мянган толгой мал отор нүүдлээр хаваржиж байна.



**Сумдад цаг үеийн ажлаар ажилласан тухай:** Сумын Онцгой комиссын ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдал, ой, хээрийн гал түймэр, коронавируст халдвар /Covid-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх эрсдлийг бууруулах чиглэлээр зохион байгуулж буй ажлыг шалган зааварлах аймгийн Засаг даргын орлогчоор батлуулсан 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдөр удирдамжаар 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Цагаан-Овоо, Баян-Уул, Баяндун, Сэргэлэн, Халхгол, Матад, Булган сумдад 2021 оны 03 дугаар сарын 25 өдрөөс 04 дүгээр сарын 01-ний өдрүүдэд ажиллалаа.

Цаг үеийн ажлаар Цагаан-Овоо, Баян-Уул, Баяндун, Сэргэлэн, Халхгол, Матад, Булган сумдад ажиллахад:

- ❖ Ноолуур 146,000 -155,000 төгрөгийн ханштай байна.
- ❖ Сумын ноолуур авч байгаа 12 иргэн 21 цэгт ариултгал халдвар хамгааллын дэглэмээ барьж ажиллаж байна.
- ❖ Том малын зүй бус хорогдол 1749 толгой мал хорогдсон байна.
- ❖ Сумдын хэмжээнд 20844 толгой мал төллөөд байна.
- ❖ Сумын аюулгүйн нөөцийн өвс, тэжээл бүрэн дууссан Цагаан-Овоо, Сэргэлэн, Матад, Баяндун, Булган, Халхгол сумын тэжээл дууссан. Сумын аюулгүйн нөөцийн өвс 3 сумын 181 тонн, 2 сумын хорголжин тэжээл 65 тонн үлдэгдэлтэй байна.

## ГАЗАР ТАРИАЛАН:

**Төлөвлөлт:** Энэ онд аймгийн хэмжээнд ХХААХҮЯамны сайд, Аймгийн Засаг

2020 оны төлөвлөгөө	Нийт үр тариа (га-аар)	Үр тариа таримлын төрлөөр (га-аар)				Бусад тарьмал (га-аар)				Нийт тариалах талбай (га-аар)	Уринчийн төлөвлөгөө (га-аар)
		Буудай	Арвай	Овьёос	Бусад үр тариа	Тосны ургамал	Малын тэжээл	Төмс	Хүнсний ногоо		
Тариалах талбай (га-аар)	22600	18500	300	300	3500	4500	2500	161	117	29878	25000
Га-ийн ургац (цн-ээр)	12.0	12.0	12.0	10.0	12.0	8.0	20.0	120.1	119.9		

даргатай байгуулсан бүтээгдэхүүний нийлүүлэх гэрээгээр 23,8 мянган.га-д үр тариа, үүнээс 26,9 мянган.га-д улаан буудай, 2,1 мянган.га-д тосны ургамал, 5,5 мянган.гад малын тэжээл 189 га-д төмс, 127 га-д хүнсний ногоо тариалж, үр тарианы ургац 29,6 мянган.тн, үүнээс 26,9 мянган .тн улаан буудай, 3,8 мянган тн бусад үр тариа, 1,4 мянган.тн тосны ургамал, 2,4 мянган.тн төмс, 1,5 мянган.тн хүнсний ногоо, 11,0 мянган.тн малын тэжээл, 1,4 мянган тонн тосны ургамал, 13 тн тонн жимс, жимсгэнэ тус тус хураан авч 24,1 мянган га-д уриншийн боловсруулалт хийхээр төлөвлөн хаврын тариалалтын бэлтгэл ажилдаа ороод байна.

Улаан буудайн үрийн хангамжийг бүрдүүлэх зорилгоор 2020 оны ургацаас 2955,5 тн үрийн нөөцийг бүрдүүлсэн бөгөөд дутагдах 611 тн үрийн буудайн захиалгыг Хөдөө аж ахуйг дэмжих сангаар дамжуулан авахаар төлөвлөөд байна.

**Хаврын тариалалтын бэлтгэл:** 2021 онд Халхгол, Баянтүмэн, Баян-Уул, Чойбалсан, Чулуунхороот, Дашбалбар, Хэрлэн, Хөлөнбуйр, Сэргэлэн, Цагаан-Овоо, Булган сумдын нутагт үр тарианы зориулалтаар 83,0 мянган.га тариалангийн газар эзэмшигч 30 аж ахуйн нэгж, 3 иргэн, төмс хүнсний ногооны 23 аж ахуйн нэгж байгууллага, 869 өрхийн тариалан эрхлэгчид байна.

Хаврын тариалалтын бэлтгэл хангахтай холбогдуулан ХХААХҮ-ийн яам, Эрүүл мэндийн яамтай хамтран Улаанбаатар хотоос орон нутагт очиж ажиллах тариаланчийг “COVID-19” эсрэг вакцинд хамруулж Улаанбаатар хотоос ирэх 140 хүнээс 47 хувь буюу 67 тариаланч вакцинжуулалтад хамрагдаад байна.

Орон нутагт 151 тариаланч вакцинд хамрагдах хүсэлтийг сумдын Хөдөө аж ахуйн тасгаар дамжуулан авч нэгтгэн Эрүүл мэндийн газарт хүргүүлэн ажилласан.

Аймгийн Онцгой комиссын 2021 оны 04 сарын 03 өдрийн 24 тоот тогтоолын хүрээнд 3 сумын 4 аж ахуйн нэгжийн 9 хүн өөрийн талбайд гарч 2 сумын 6 аж ахуйн нэгжийн 36 тариаланч аймгийн төвд тусгаарлалтад байна.

**Цахим сургалт:** ХХААХҮ-ийн яамны захиалгаар НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилтээр 2021 оны 04 сарын 22-нд зохион байгуулагдсан "Ургамлын гарал үүсэл, пестицидийн бүртгэл хяналтын систем"-ийг нэвтрүүлэх цахим сургалтад 14 сумын Хөдөө аж ахуйн тасгийн Газар тариалан хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулав.

## **ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

**Ахуйн нэгжийн дэлгэрэнгүй судалгаа:** ХХААХҮ-ийн яамны Жижиг, дунд үйлдвэрийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу аймгийн хэмжээнд татвар болон нийгмийн даатгал төлдөг 1193 аж ахуйн нэгж, ахуйн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй 240 иргэн, аж ахуйн нэгжийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж, Жижиг, дунд үйлдвэрийн газарт хүргүүлэн ажилласан.

“Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн” аяны хүрээнд аймаг сумын “Сор” бүтээгдэхүүний судалгааг гарган Жижиг, дунд үйлдвэрийн газарт хүргүүлсэн.

**Сум хөгжүүлэх сангийн мэдээлэл:** Сум хөгжүүлэх сангийн мэдээллийг Монгол банкуу татаж байгаатай холбогдуулан алдаатай татагдсан 21 зээлдэгчийн мэдээллийг залруулан дамжуулаад байна.

Засгийн газраас хэрэгжүүлж буй “Ажлын байрыг дэмжих зээл”-ээс Төрийн банкаар дамжуулан авч буй 80,0 сая төгрөгийн зээлийн /Дорнын үүрийн цолмон ХХК/ батлан даалтын гэрээг баталгаажуулсан.

**Хөтөлбөр батлуулсан тухай:** “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр III”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулсан.

### **ХҮНС, ХУДАЛДАА, ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ:**

**Хүнсний бүтээгдэхүүний нөөцийн судалгаа, үнийн мэдээ:** Хүнсний бараа бүтээгдэхүүний үйлдвэр, худалдаан дахь үлдэгдлийн нөөцийн мэдээг 14 сумаас авч аймгийн хүн амын хоногийн хэрэгцээнд харьцуулан гаргаж 7 хоног бүрийн даваа, пүрэв гарагт ХХААХҮ-ийн яам болон аймгийн Засаг даргын Тамгын газрын ХОХБТ-ийн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбатын өгсөн үүрэг чиглэлийн дагуу 3 ажлын хэсэг Хэрлэн сумын 11 багийн 34 хүнсний дэлгүүрээс гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үнийн судалгаа авч 3 дугаар сарын үнийн судалгаатай харьцуулалт хийж аймгийн онцгой комист танилцуулж ажиллалаа.

Мөн аймгийн Засаг даргын А/565 дугаар захирамж “Зарим төрлийн үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийн тогтвортой үйл ажиллагааг хангах талаар авах арга хэмжээний тухай” түр журмын хэрэгжилттэй танилцан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Дорнод аймгаас экспортлох боломжтой бүтээгдэхүүн, түүний нөөц, Улаанбаатар хотруу нийлүүлдэг бүтээгдэхүүний талаар дэлгэрэнгүй судалгааг хийж мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газрын ХОХБТ-ийн хэлтэст танилцуулж ажилласан.

**Хүнс түгээлтийн зөвшөөрөл олгосон тухай:** 2021 оны 04 сарын 19-ны өдрөөс эхлэн аймгийн Онцгой комиссын 33 дугаар тогтоол “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн”-тэй холбогдуулан Чойбалсан хот дотор хүнс, ус түгээлтийн “ХҮ” зөвшөөрлийг хүнсний үйлдвэр, цех, худалдааны төвүүд болон хүнсний худалдааны албан ёсны дистрибьюшинүүдэд олгон ажиллаж байна.

2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар 123 аж ахуйн нэгжийн 203-н тээврийн хэрэгсэлд зөвшөөрлийн хүсэлт ирүүлснээс 150 тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгоод байна.

**Хүнсний үйлдвэрлэл, хүнсний худалдааны салбарын ажиллагсдын судалгаа:** Коронавируст халдвар /covid-19/-ын цар тахлын улмаас “Бүх нийтийн бэлэн байдал”-ын зэрэгт шилжсэнтэй холбоотой улаан түвшинд үйл ажиллагааг

хязгаарлаагүй салбар болох хүнсний үйлдвэрлэл, хүнсний худалдааны салбарын ажиллагсдын дэлгэрэнгүй судалгааг 14 сумаас авч, нэгтгэж ажилласан.

Аймгийн хэмжээнд хүнсний худалдаа эрхэлж буй 303 аж ахуйн нэгжийн 1140 ажиллагсад байна. Үүнээс: **639** нь худалдагч байна.

**Аж ахуйн нэгжийн нөлөөллийн судалгаа:** 2021 оныг “Хувийн хэвшлийг дэмжих” жил болгон зарласантай холбогдуулан “сovid-19” цар тахлын нөхцөл орон нутгийн аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хэрхэн нөлөөлж буй байдалд дүгнэлт хийх, судалгааг мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа тус бүрээр авч нэгтгэж ажилласан.

### **СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

ХХААХҮ-ийн яам, орон нутаг, холбогдох байгууллагаас зохион байгуулсан 5 удаагийн цахим сургалтанд давхардсан тоогоор 20 албан хаагч, хамруулж, хариуцсан ажил үүргийг үр дүнтэй гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг чадварыг эзэмшүүлэн ажиллаж байна.

Сумдын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдийг салбарын цаг үеийн мэдээллээр хангах, салбарын холбогдолтой үүсэж байгаа аливаа асуудлыг тодорхойлох, эрчимжүүлэх, ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор сумдын хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдтэй 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр цахим хурал зохион байгуулж, салбарын холбогдох мэдээ мэдээлээр ханган ажиллалаа.

### **КОРОНАВИРУС ХАЛДВАР(COVID-19)-ЫН ЦАР ТАХАЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ:**

**Хүнс тээврийн хяналт:** 2021 оны 03 дугаар сарын 29 нөөс 04 дүгээр сарын 27-ны хооронд Улаанбаатар хотоос Чойбалсан хот руу хүнс тээврийн нийт 226 тээврийн хэрэгсэл 282 жолооч ирснээс 24 цагтаа 154 тээврийн хэрэгсэл 182 жолооч Улаанбаатар хот руу буцаж, 72 тээврийн хэрэгсэл 100 жолооч гэрийн тусгаарлалтад орсон.

**Үүнээс:** Гурванзагал сум руу 1 тээврийн хэрэгсэл 2 иргэн, Чойбалсан сум руу 1 тээврийн хэрэгсэл 5 иргэн, Дашбалбар сум руу 1 тээврийн хэрэгсэл 1 иргэн, Баян-Уул сум руу 2 тээврийн хэрэгсэл 4 иргэн, Цагаан-Овоо сум руу 3 тээврийн хэрэгсэл 3 иргэн, Халхгол сум руу 1 тээврийн хэрэгсэл 2 иргэн явж тухайн сумандаа тусгаарлагдсан.

Зөрчил гаргасан 2 тээврийн хэрэгсэл 3 жолоочийг цагдаагийн байгууллагад мэдэгдэж албадан тусгаарлах байранд тусгаарлаж, тээврийн хэрэгслийг журамлан ажилласан.

### **МАЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР**

**Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар:** Малын эмч мэргэжилтнүүдийг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт 2021 оны арга хэмжээг хэрэгжүүлэх үед коронавируст халдвар (COVID-19) цар тахлаас



урьдчилан сэргийлэх халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэх удирдамжийг аймгийн Онцгой комиссын 44 дүгээр тогтоолоор баталгаажуулж цар тахлын халдварлалт өндөр байгаа Хэрлэн, Хөлөнбуйр, Цагаан-Овоо, Дашбалбар сумдаас бусад 10 суманд мал эмнэлгийн арга хэмжээг зохион байгуулж ажиллаж байна.

Төлөвлөгөөт арга хэмжээний хүрээнд Дуут хавдар, ДХХ, Энтериобактериоз, Цусан халдварт, Гахайн (ЦХИБ) халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 368,000 толгой мал, амьтан хамруулахаас 68,460 толгой мал, амьтан хамруулж 18,6 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

**Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, халдваргүйтгэлийн талаар:** Аймгийн Онцгой комиссын 38 дугаар хуралдааны шийдвэрийн дагуу коронавируст халдварын эрсдэлийг бууруулах, тэмцэх зорилгоор 14 сумын хэмжээнд халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж нийт 616,348 м<sup>2</sup> талбайд халдваргүйтгэл хийж ажилласан. Үүнээс нийтийн эзэмшлийн 591,584 м<sup>2</sup>, байгууллагын оффисын байрын 23,518 м<sup>2</sup>, бохирын цооногын 1,192м<sup>2</sup>, машин техник хэрэгсэл 27, бусад 54м<sup>2</sup>

**Мал, амьтны халдварт өвчнөөс сэргийлэх хорогдсон малын сэг зэмийг устгах халдваргүйтгэлийн талаар:** Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 01 тоот албан даалгавар, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны А/47 дугаар тушаалаар баталсан ажлын төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2021 оны А/172 дугаар захирамжийн дагуу 14 сумын хэмжээнд сэг зэм цуглуулах булж устгах, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Халдваргүйтгэлийн арга хэмжээний гүйцэтгэл 2021 оны 04 дүгээр сарын 29-ний байдлаар нийт 8315 толгой мал, амьтны сэг зэмийг цуглуулж, 4282 сэг зэмийг устган, нийт 56,423 м<sup>2</sup> талбайд хийж ажилласан байна.

**Мал эмнэлгийн лабораторийн талаар:** Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/82 тоот тушаалаар томилогдсон 3 хүний бүрэлдэхүүнтэй үнэлгээний баг аймгийн Мал эмнэлгийн лабораторит цахим үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Үнэлгээний баг мал эмнэлгийн сорилтын лабораторийн 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн “Итгэмжлэл техникийн хурал”-аар /MNS ISO IEC 17025:2018/ стандартын хүрээнд 4 жилийн хугацаатай итгэмжлэгдсэн лабораторийн эрх авсан байна.

**Сургалт зөвлөгөөний талаар:** Төрийн албаны салбар зөвлөл, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын санаачлагаар MERIT төсөлтэй хамтран зохион байгуулсан “Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт-хяналт шинжилгээ үнэлгээ” цахим сургалтад аймгийн Мал эмнэлгийн газар, сумын Мал эмнэлгийн тасгийн нийт 17 албан хаагч, мэргэжилтэн хамрагдсан.

## **ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

### **ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР:**

Газрын кадастрын мэдээллийн санд 89 иргэн, аж ахуйн нэгжийн кадастрын зургийг оруулж өөрчлөлт хийсэн. Дундын мэдээллийн сангаар дамжуулж 25 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг илгээж гэрчилгээ олгох, гэрээ байгуулах ажлыг гүйцэтгэсэн байна. Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу 1:1000 масштабтай байр зүйн зургийн “инженерийн шугам сүлжээний давхарга”-ын өгөгдөл, мэдээллийг засварласан.

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас зохион байгуулж буй газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн цахим систем, газрын кадастрын мэдээллийн сан, хаягийн мэдээллийн сан, газрын үнэлгээний систем зэрэг тус салбарт хэрэгжиж буй программ хангамжийн талаарх заавар зөвлөмж өгөх цахим сургалтад аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтнүүд хамрагдсан.

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас зохион байгуулсан Газрын ерөнхий хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Гарын төлбөрийн тухай хууль, Кадастрын тухай хууль, Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэлэлцүүлэгт оролцон санал өгөх ажлыг зохион байгуулсан.

### **БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Covid-19 цар тахлын дэгдэлтийг хязгаарлах, сэжигтэй тохиолдлуудыг тусгаарлах зорилгоор Хэрлэн сумын нутаг дэвсгэрт 25,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Бүжнэр” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн “Эрүүл мэнд, боловсрол, соёлын салбарын төсөвт байгууллагын цахилгаан, сантехникийн системийг засварлах, шинэчлэх ажилд дэмжлэг” ажлын Багц-1 болох “Зоонозын төвийн барилгын ариун цэврийн өрөөний засвар” ажлыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2021 оны А/08 дугаар тушаалаар байгуулагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллан ашиглалтад хүлээн авсан.

Эмнэлгийн бүсийн авто замын орц, гарцын асуудлаар холбогдох байгууллагуудтай санал солилцож, Зүүн бүсийн тулгуур төв Чойбалсан хотын 2030 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд уялдуулан загвар зургийг боловсруулсан.

2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлын саналд Чойбалсан хотын үерийн ус зайлуулах, цуглуулах, үерийн хамгаалалтын далан суваг байгуулах ажил, Хэрлэн голын дунд гүүр, 3,4 км авто зам, Булган сумын нутаг дэвсгэрт байрлах Тугийн сүмийг сэргээн барих, аймгийн төвлөрсөн хогийн цэгийн байгууламж барих, хогийн цэгийн байгууламж хруу авто зам барих, Чойбалсан-



Хавирга чиглэлийн 142,3 км авто зам барих зэрэг ажлуудын саналыг хүргүүлсэн.

Нийтийн зориулалттай орон сууцны барилгын цахилгаан шат /лифт/-ны судалгааг гарган Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд нийтийн зориулалттай орон сууцны барилгын цахилгаан шат /лифт/ бүхий 10 барилга байгууламж байгаа бөгөөд ашиглалтын үеийн үйл ажиллагааг “Гэрэлт урсгал” ХХК хариуцан ажиллаж байна.

Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 38 дугаар тушаалаар батлагдсан “Хот байгуулалтын мэдээллийн сангийн журам”-д заасны дагуу аймгийн хот байгуулалтын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, нэг эх үүсвэртэй иж бүрэн нэгдмэл мэдээллийг үйл ажиллагаандаа ашиглаж хэвших, хэрэглэгчдийг бодит мэдээллээр хангах ажлын хүрээнд 2021 оны 04 сарын 01-ээс 30-ны өдрүүдэд Хэрлэн сумын 1, 6, 7, 9 дүгээр багийн нийт 344 барилгын фасад зургийг авч, судалгаа мэдээллийг цаасан хэлбэрээр бүрдүүлж, хот байгуулалтын мэдээллийн санд /urban.gov.mn/ 128 барилга байгууламжийн мэдээллийг бүрэн оруулаад байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан “Боловсролын салбарын сургууль, цэцэрлэг, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох” зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Дашбалбар сумын 320 хүүхдийн хүчин чадалтай бага сургуулийн хичээлийн барилга, Баян-Уул сумын 5 дугаар багт байрлах бага сургууль, 100 хүүхдийн дотуур байр, Хилийн цэргийн отрядын 25 хүүхдийн цэцэрлэг, Эрээн багийн 25 хүүхдийн цэцэрлэгийн нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлын даалгаврыг боловсруулан холбогдох газар, хэлтсийн дарга нараар хянуулж, аймгийн Засаг даргаар баталгаажуулан Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд нурах аюултай, осол гаргах эрсдэлтэй олон нийтийн барилга байгууламж, орон сууцыг буулган шинээр барих төсөл ажлын хэрэгжилтийг Газар зохион байгуулалт, Геодези, Зураг зүйн газарт хүргүүлсэн.

## **БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**

“Дорнод аймгийн 9 гайхамшиг” сэдвүүдээр тус бүр 5 минутын цахим контентийг Жаран телевизээр хийлгэж цахим хуудсууд болон орон нутгийн телевизүүдээр цацуулаад байна.

“Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах” санаачлагыг өрнүүлэх, “Хаягдал батерей цуглуулах” аянд аж ахуй нэгж, байгууллагыг нэгдэхийг уриалсан мэдээ, мэдээллийг байгууллагын болон байгаль хамгаалагчдын цахим хаягаар олон нийтэд сурталчилж байна.

“Royal palace”, “Ташгайт” зочид буудал, ресторанд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргасан.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 онд мэдээлэл, сургалт сурталчилгааны хүрээнд анимашн хэлбэрээр богино хэмжээний видео шторкоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар

батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний журмын хэрэгжилт, иргэдэд өгөх зөвлөгөөг “Жаран” телевизээр хийлгэж бэлэн болгосон.

“Хуванцар савнаас татгалзая” сэдвийн “Хог хаягдлаа эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хэвшүүлэе” ажлын тайланг нэгтгэн аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэст хүргүүллээ.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гадаад Харилцаа, Аялал Жуулчлалын Бодлогын Хорооны хоёр дахь удаагийн хуралдааны шийдвэрээр гарсан зорилтод ажлуудыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулж хүргүүлэн ажилласан.

Ачаа тээврийн хяналтад Улаанбаатар хот болон бусад аймаг орон нутгаас ирж буй жолооч зорчигч нарыг тусгаарлах байранд хүргэх хяналтын ажилд газрын албан хаагчид 5 хоног ажиллаа.

Зүй бусаар Баян-уул суманд хорогдсон 2 цагаан зээрнээс аймгийн Мал эмнэлгийн газартай хамтран дээж авч, халдваргүйтгэл хийж сэг зэмийг булах ажлыг зохион байгууллаа.

Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналуудыг нэгтгэн асуумжийн хамт ЗДТГ-ын ХОХБТХ-ийн ахлах мэргэжилтэн Болормаад хүргүүлсэн.

Улсын хэмжээнд “Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаа-2021” судалгаа явагдаж байгаатай холбогдуулан уг Монгол бичгийн судалгаанд газрын мэргэжилтнүүд, 14 сумын байгаль хамгаалагчид нийт 28 албан хаагчдыг судалгаанд бүрэн хамруулсан. Тайлан мэдээг гаргаж аймгийн Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Төмөрчимэгт цахимаар хүргүүлсэн.

Хүүхэд гэр бүл хөгжлийн газраас зохион байгуулсан аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн цахим хуралд оролцсон. Уг хурлаар аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр албан даалгавар, 2020 оны хүүхдийн төлөө зөвлөлийн ажлын тайлан, 2021 оны зөвлөлийн ажлын төлөвлөгөөг хэлэлцсэн.

Дорнод аймгийн Дашбалбар, Цагаан-Овоо, Матад, Халхгол, Чулуунхороот, Баян-Уул сумдад хэрэгжиж байгаа Монгол орны Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг бэхжүүлэх биологийн олон янз байдал орчны бүс дэх орон нутгийн ард иргэдийн амьжиргааг дэмжих KFW төслөөс зохион байгуулж байгуулсан тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдад өөрийн орон нутгийн байгалийн болон соёлын өв, нөөцийн талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, тэдгээрийг таньж судлах, мэдлэг чадвар олгож, чадавхжуулах зорилго бүхий цахим уулзалтад оролцлоо. Энэ оны 5 дугаар сард төсөлд хамрагдсан сумдын Ерөнхий боловсролын сургуулийн биологийн танхимын

тоног төхөөрөмж, сургалтын материалыг иж бүрнээр хангаж, эко кабинет тохижуулж өгөх юм.

Монгол улсын хэмжээнд гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлж, халдвар тархалтын улаан түвшинг тогтоосонтой холбогдуулан мод тарих хаврын аяныг аймгийн хэмжээнд олон нийтийг хамруулан зохион байгуулах боломжгүй болоод байгаа билээ. Иймд аймагт мод үржүүлдэг иргэн, аж ахуйн нэгжүүдийн модны тарьц суулгацын судалгааг гаргаж байгууллагын цахим хуудсаар дамжуулан хашаа орчин тойрондоо мод тарьж ургуулах сонирхолтой иргэд, ААНБ-уудад сурталчилан ажиллаж байна. мөн өөр бусад аймгаас хангагдах боломжгүй мод сөөгийг авах боломжтой найдвартай мод үржүүлгийн газруудын судалгааг гаргаж байгууллагын фэйж, фэйсбүүкүүд, дорнод аймгийн группүүдэд тавьж мэдээллэж байна

### СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХҮРЭЭНД:

Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь “Стандартчилал, техникийн зохицуулалт тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль”, “Хэмжил зүйн тухай хууль”-ийн хэрэгжилтийг ханган дараах ажлыг хийж гүйцэтгэсэн.

- Экспортын бүтээгдэхүүн баталгаажуулалт

Д/д	Нэр төрөл	Тохирлын гэрчилгээний тоо	Хэмжээ /тн/	Аж ахуйн нэгж
1.	Хар тугалганы баяжмал	16	96	1
2.	Цайрын баяжмал	94	6016	
3.	<b>Нийт</b>	<b>110</b>	<b>6112</b>	

- Стандартын лавлагаа, мэдээлэл

д/д	Стандартын төрөл	Стандартын тоо	Иргэн	Аж ахуйн нэгж
1.	MNS	2	2	2
2.	ISO	1	1	1
3.	<b>Нийт</b>	<b>3</b>	<b>3</b>	<b>3</b>

- Цахилгаан хэмжих хэрэгслийн чиглэлээр

д/д	Хэмжих хэрэгслийн нэр	1 фаз	3 фаз
1.	Цахилгааны тоолуур	219	9
2.	<b>Нийт</b>	<b>228 ш</b>	

- Эзлэхүүн зарцуулалтын чиглэлээр

д/д	Хэмжих хэрэгслийн нэр	Тоо /ш/
1.	Шатахуун түгээгүүр	2
2.	Автоцистерн	45

3.	<b>Нийт</b>	<b>47</b>
----	-------------	-----------

- Механик, даралт, температурын чиглэлээр

д/д	Хэмжих хэрэгслийн нэр	Тоо /ш/
1.	Авто пүү	1
2.	<b>Нийт</b>	<b>1</b>

4 дүгээр сард нийт 110 ширхэг тохирлын гэрчилгээ, 276 ширхэг хэмжих хэрэгслийн гэрчилгээ олголоо.

